



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

42017 Чойр, Говьсүмбэр аймаг,
Утас: 7054-3118, E-mail: GSAimag@yahoo.com

2016. 08. 17 № 07/285
танай _____-ны № _____-т

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ

Тус аймгийн Засаг даргын Тамгын газрын
2016 оны авлигын эсрэг төлөвлөгөөг батлан
хүргүүлэв.

Хавсралт 9 хуудастай.

ДАРГА



Б.БАТДЭЛГЭР



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 1106

Чойр

Авлигын эсрэг төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 33.1.5, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.1, 7.6.2, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2016 оны “Авлигын эсрэг төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. “Авлигын эсрэг төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлуудад хяналт тавьж ажиллах, холбогдох мэдээ тайлан, эрх зүйн баримт бичгүүд, цаг үеийн мэдээ мэдээллийг аймгийн цахим хуудсанд хугацаанд нь түргэн шуурхай оруулж хариуцлагатай ажиллахыг хэлтэс, тасгийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, “Авлигын эсрэг төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг Хууль зүйн хэлтсийн дарга /П.Наранхүү/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БАТДЭЛГЭР

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
2016 оны 12 сарын 15 ны өдрийн /106/
дугаар тушаалын 10-р хавсралт

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2016 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт			Хариуцах хэлтэс, байгууллага, албан тушаалтан	Хамтрах хэлтэс, газар
		Хөрөнгө санхүү	Хугацаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		
НЭГ. ЁС ЗҮЙТЭЙ МАНЛАЙЛАЛ						
<i>а/ Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх</i>						
1.1	Аймгийн ЗДТГ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг /батлагдсан/ АТГ-т хүргүүлэх	Шаардахгүй	2016 оны 1-р улиралд	-Төлөвлөгөө АТГ-т хүргэгдсэн байх -Нийтэд мэдээлэгдсэн байх	Хууль зүйн хэлтэс	Бусад хэлтэс
1.2	Аймгийн засаг даргын Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн тайланг хагас жил, бүтэн жилээр тайлагнах	Шаардахгүй	2016 оны 2, 4-р улиралд	-Хэрэгжилтийн түвшин тодорхойлогдсон байх	Хяналт шинжилгээ үнэлгээний тасаг	Бусад хэлтэс
<i>б/ Авлигын эсрэг хууль тогтоомжийн сургалт сурталчилгаа, албан тушаалтануудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хариуцсан эрх бүхий ажилтаны ажлын байрны нөхцөлийг сайжруулах</i>						
1.3	Авлигын эсрэг үйл ажиллагаа хариуцсан ажилтан /ЭБАТ/-ыг чадавхижуулах, сургалтад хамруулан сургагч багшийн түвшинд хүргэх, байгууллага салбар нэгжид авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилах, сургалт, соён гэгээрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх	Байгууллагын төсөв	Жилдээ	ЭБАТ ажилтны чадавхи сайжирсан байна.	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Хууль зүйн хэлтэс
<i>в/ Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах</i>						

1.4	Аймгийн болон байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг хангахын тулд цахим хуудас болон мэдээллийн самбар, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх	Байгууллагын төсөв	Тухай бүр	-Нийтэд хамрааралтай шийдвэр олон нийтэд мэдээлэгдсэн байх	Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс	Хууль зүйн хэлтэс
г/ Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт						
1.5	Аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдах ажилтнууд авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлээ илэрхийлж амлалт өгч, шударга ёсыг тогтоох, авлига хүнд сурталгүй ажиллах талаар албан хаагчдад болон олон нийтэд мэдэгдэл хийх	Шаардахгүй	2016 оны 3-р сард	-Тодорхой арга хэмжээ зохион байгуулагдсан байх -Ёс зүйн алдаа зөрчил гарсан байдал	Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс	Бусад хэлтэс, алба тасаг
д/ Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах						
1.6	Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчилах - мэдээллийн самбар - хэвлэмэл материал - цахим хуудас - мессеж мэдээлэл - сургалт сурталчилгаа	Байгууллагын төсөв	Тухай бүр	-Нийтэд мэдээлсэн байх -Хууль зүйн хэлтсийн төлөвлөгөөт эрх зүйн сургалт сурталчилгааны хүрээнд хууль тогтоомжийг сурталчлах	Хууль зүйн хэлтэс	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс
1.7	Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх	Шаардахгүй	Тухай бүр	Үйл ажиллагааны үр дүнд үндэслэх	Хууль зүйн хэлтэс	-
ХОЁР. ШУДРАГА БАЙДАЛ						
а/ Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох						
2.1	Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, хариуцсан ажил үүргийн талаарх мэдээллийг иргэд	Шаардахгүй	Жилдээ	-Албан хаагч бүрийн ажил үүргийн талаарх хуваарь олон нийтэд ил байрласан	Төрийн захиргаа удирдлагын	Нийтлэг үйлчилгээ-ний алба

	олон нийтэд нээлттэй байлгах			байх -Тухайн албан тушаалтныг олоход хялбар болох	хэлтэс	
2.2	Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн албан хаагчид хариуцлага тооцож, зөрчлийн талаарх бүртгэл, хөтлөлтийг зохион байгуулна.	Өөрсдийнх нь зардлаар	Жилдээ	-Тогтмол утас, цахим шуудан ажиллуулсан байна -Нийтэд мэдээлсэн байна -Хариуцлага тооцсон байна -Бүртгэл хөтөлсөн байна	Ёс зүйн хороо	Бусад хэлтэс, алба тасаг
2.3	Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгаж хариуцлага тооцох	Өөрсдийнх нь зардлаар	Жилдээ	-Хуульд нийцсэн байна -Дүгнэлт гаргасан байна	Ёс зүйн хороо	Бусад хэлтэс, алба тасаг
б/ Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг мэдэгдэл, хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлэх						
2.4	Ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв мэдүүлэхийн ач холбогдолын талаар байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулах, энэ талаар мэдлэгтэй болгох	Жилдээ	2016 оны 1-4-р улиралд	-Сургалтанд бүрэн хамрагдсан байх -Сургалт давтамжтай байх -Сургалт үр дүнгээ өгсөн байх	Хууль зүйн хэлтэс	Бусад хэлтэс, алба тасаг
2.5	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргах		2016 оны 1-р улиралд	-Урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хүргүүлж дүгнэлт ирсний дараа томилгоог хийж хэвших -ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гаргуулан тайланг АТГ-т хүргүүлсэн байх	Хууль зүйн хэлтэс	Бусад хэлтэс, алба тасаг
ГУРАВ. ИЛ ТОД БАЙДАЛ						
а/ Хүний нөөцийн ил тод байдлыг хангах						
3.1	Сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах үйл ажиллагааны талаарх мэдээлэл, журмыг олон	Шаардахгүй	Тухай бүр	-Нийтэд мэдээлсэн байна -Цахим хуудаст байршуулах	Төрийн захиргаа, удирдлагын	Бусад хэлтэс, алба тасаг

	нийтэд нээлттэй байлгах				хэлтэс	
3.2	Хүний нөөцийн бодлого, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах		Тухай бүр	-Нийтэд мэдээлсэн байна -Цахим хуудаст байршуулах		
3.3	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх гүйцэтгэлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод байлгах		Тухай бүр	-Нийтэд мэдээлсэн байна -Цахим хуудаст байршуулах		
б/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах						
3.4	Худалдан авах ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг нийтэд зарлах, вэб сайтад байршуулах	Шаардахгүй	Тухайн жилийн төсөв батлагдсанаа с хойш 1 сарын дотор	-Холбогдох байгууллагад хандсан байна. -Нийтэд мэдээлсэн байна.	Хөгжлийн бодлогын хэлтэс	Худалдан авах ажиллагаа-ны алба
3.5	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх	Шаардахгүй	Жилдээ	Төлөвлөгөө, гүйцэтгэлд тулгуурлах	Хөгжлийн бодлогын хэлтэс	Худалдан авах ажиллагаа-ны алба
3.6	Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх	Байгууллагын төсөв	Тухай бүр	Төлөвлөгөө, гүйцэтгэлд тулгуурлах	Хөгжлийн бодлогын хэлтэс	Худалдан авах ажиллагаа-ны алба
3.7	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/-ийг цахим хуудсанд байршуулах	Шаардахгүй	Тухай бүр	Төлөвлөгөө, гүйцэтгэлд тулгуурлах	Хөгжлийн бодлогын хэлтэс	Худалдан авах ажиллагаа-ны алба
3.8	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсандаа байршуулсан байх	Шаардахгүй	Тухай бүр	Төлөвлөгөө, гүйцэтгэлд тулгуурлах	Хөгжлийн бодлогын хэлтэс	Худалдан авах ажиллагаа-ны алба
3.9	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох	Шаардахгүй	Хуулийн хугацаанд	Бодит байдалд тулгуурлах	Хөгжлийн бодлогын	Худалдан авах

	байгууллагад мэдээлсэн байх				хэлтэс	ажиллагаа-ны алба
3.10	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах	Шаардахгүй	Тухай бүр	Аудитын байгууллагаас хийсэн тайлан, дүгнэлтэд үндэслэх	Хөгжлийн бодлогын хэлтэс	Худалдан авах ажиллагаа-ны алба
3.11	Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх	Шаардахгүй	Тухай бүр	Төлөөллийг оролцуулах	Хөгжлийн бодлогын хэлтэс	Худалдан авах ажиллагаа-ны алба
в/ Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл бүртгэлийн үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгах						
3.12	Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах	Шаардахгүй	Жилдээ	-Нийтэд боломжит хэлбэрээр мэдээлэгдсэн ил тод болсон байна. -Вэб сайтад байршсан байна.	Хөгжлийн бодлогын хэлтэс	Нийгмийн хөгжлийн хэлтэс
3.13	Дээрх зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсандаа байршуулах	Шаардахгүй	Тухай бүр	Холбогдох журам цахим хуудсанд байршсан байна	Хөгжлийн бодлогын хэлтэс	Нийгмийн хөгжлийн хэлтэс
3.14	Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	Шаардахгүй	Тухай бүр	Мэдээлэл, ойлгомжтой байдлаар тавигдсан байна.	Хөгжлийн бодлогын хэлтэс	Нийгмийн хөгжлийн хэлтэс
г/ Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх						

3.15	Тухайн жилийн төсөв/1 дүгээр сарын 10-ны дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/, дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор/-ийг цахим хуудсандаа байршуулах	Шаардахгүй	Жилдээ	-Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан шаардлагын дагуу мэдээлэх, веб сайтад байршуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Хөгжлийн бодлогын хэлтэс
3.16	2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан /4 дүгээр сарын 1-ний дотор/-г цахим хуудсандаа байршуулах	Шаардахгүй	4 дүгээр сарын 01-ний дотор	-Төсвийн тухай, Аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудад заасан хугацааг харгалзан үзэх	Санхүү төрийн сангийн хэлтэс	Хууль зүйн хэлтэс
3.17	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /4 дүгээр сарын 1-ний дотор/-ийг бүрэн эхээр нь цахим хуудсандаа байршуулах	Шаардахгүй	2016.04.01-ний дотор	-Төсвийн тухай, Аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудад заасан хугацааг харгалзан үзэх	Санхүү төрийн сангийн хэлтэс	Аудитын газар
3.18	Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх /өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт	Шаардахгүй	Өөрчөлт орсноос хойш ажлын 14 хоногт багтаан	Хуульд заасан хугацааг харгалзах	Санхүү төрийн сангийн хэлтэс	-
3.19	Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/	Шаардахгүй	2016 оны 04 сарын 01-ний дотор	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан	Санхүү төрийн сангийн хэлтэс	-
д/ Иргэдийн өргөдөл, санал, мэдэгдэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх						
3.20	Иргэдээс өргөдөл гомдол хүлээн авах нээлттэй утас ажиллуулж, түүний сайн туршлагыг бусад байгууллагад нэвтрүүлэх	Шаардахгүй	Тогтмол	-Иргэдийн төрд хандах хандлага зэрэг болж өөрчлөгдөнө. -Хэрхэн шийдвэрлэсэн талаарх хариу өгч хэвшсэн байдлаар	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс	Бусад хэлтэс, алба тасаг
3.21	Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр,	Байгууллагын төсвөөр	2016 оны 1-р улиралд	Өргөдөл, гомдол хүлээн авах нөхцөл бүрдсэн байна.	Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс	Бусад хэлтэс, алба тасаг

	факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)					
3.22	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх	Шаардахгүй	Тухай бүр	Шийдвэрлэсэн талаархи мэдээллийг мэдээлнэ.	Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс	-
ДӨРӨВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ						
<i>а/ Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах</i>						
4.1.	Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуулсан байх	Шаардахгүй	1-р улиралд	Хяналт шалгалтын төлөвлөгөө цахим хуудсанд байршсан байна.	ХШҮТасаг	-
4.2.	Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байх /цахим хуудсаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх/	Байгууллагын төсвөөр	Тухай бүр	Хяналт шалгалтын дүнг үндэслэх	ХШҮТасаг	-
4.3	Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ/дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх	Шаардахгүй	Тухай бүр	Хяналт шалгалтын дүнг үндэслэх	ХШҮТасаг	-
<i>б/ Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэх</i>						
4.4	Албан тушаалтнууд албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн авлигын зөрчлийн талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх, хянан шалгаж буй материалыг харьяаллын дагуу шилжүүлэх	Шаардахгүй	Тухай бүр	-Авлигатай тэмцэх газарт мэдээллийг шилжүүлсэн байна	Хууль зүйн хэлтэс	Бусад хэлтэс, алба тасаг
<i>в/ Авлигын эсрэг хууль тогтоомж зөрчигчдөд хариуцлага тооцох</i>						
4.5	Холбогдох эрх бүхий байгууллагаас зөрчлийг хянан тогтоож ирүүлсэн	Шаардахгүй	Шаардахгүй	-Хариуцлага тооцсон байх	Хууль зүйн хэлтэс	Бусад хэлтэс, алба тасаг

	мэдэгдэл, хариуцлага тооцуулах саналын дагуу хуулийн хүрээнд арга хэмжээг авах					
4.6	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль зөрчсөн этгээд Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 04 сарын 24-ний өдрийн 74 дүгээр тушаалын хавсралтын дагуу сахилгын шийтгэлийн талаарх мэдээллээ холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээг хэвшүүлэх	Шаардахгүй	Шаардахгүй	-Мэдээлэл холбогдох этгээдэд хүргэгдсэн байх -Олон нийтэд мэдээлсэн байх	Хууль зүйн хэлтэс	Бусад хэлтэс, алба тасаг